



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 4/378

Хэрлэн сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 'а' дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжинд тусгагдсан төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчилтэй холбоотой шийдвэрийг нийтэд ил тод зарлаж байх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Төрийн албан хаагч өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг нийтэд хүргэх тухай" журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Гантулга/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА



“ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ӨӨРТ НОГДУУЛСАН САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ ТУХАЙ” ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар төрийн албан хаагчид хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай мэдээллийг бэлтгэх, нийтэд мэдээлэх үүргийг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан хариуцна.

1.3. Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг уг шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн тооллоор 30 хоног /гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан/ өнгөрсний дараа нийтэд мэдээлнэ.

1.4. Мэдээллийг нийтэд мэдээллэхэд тухайн албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

Хоёр. Нийтэд мэдээлэх

2.1. Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

2.1.1. Өдөр тутмын сонинд нийтлүүлэх;

2.1.2. Харьяалах байгууллагын цахим хуудсанд нийтлэх;

2.2. Нийтэд хүргэх мэдээлэлд сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн овог, нэр, байгууллагын нэр, албан тушаал, сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл, сахилгын шийтгэлийн төрөл, нийтэд мэдээлсэн хэлбэр, хугацааг тусгана.

2.3. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг энэхүү журмын 2.1-д заасан хэлбэрээр хүргэх үүргийг журмын 1.2-т дурдсан хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

Гурав. Бусад зүйл

3.1. Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан талаарх журмын 2.2-т заасан мэдээллийг улирал бүрийн 25-ны өдрийн дотор тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бүх байгууллага хүргүүлнэ.

3.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн мэдээлэл, шийдвэрийг хүлээн авч, нэгдсэн сан бүрдүүлэн ажиллана. Сан нь олон нийтэд нээлттэй байна.

3.3. Энэхүү журмын заалтыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.